

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БА МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ НИЙЦЭЛ

Хуульч, өмгөөлөгч Б.Энхцэцэг

### УДИРТГАЛ

Байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудал нь зөвхөн нэг улсаар тогтохгүй, бүс нутаг, цаашлаад дэлхий дахин, хүн төрөлхтөний ирээдүй хойчид ач холбогдолтой болохын хувьд улс орнууд уур амьсгалын өөрчлөлт, байгалийн тэнцвэрт байдал, тогтвортой хөгжлийн зорилтуудыг чухалчлах болж, энэ талаарх олон улсын хамтын үйл ажиллагаа улам өргөжин тэлж байна.

Монгол Улс нь олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүний хувиар Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын болон олон улсын бусад гэрээ, конвенцод нэгдэн орж, тэдгээрийг хэрэгжүүлэх үүрэг амлалтыг олон улсын өмнө авсан билээ. Энэ нь манай улс аливаа асуудлыг дан ганцаар шийдвэрлэх боломжгүй тохиолдолд, олон улсаас дэмжлэг тусалцаа авах хамтын ажиллагааны суурь нөхцөл болдог.

Монгол Улс биологийн олон янз байдал, агаар, хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын

доройтол зэрэг байгаль орчны чиглэлээрх олон улсын 12 гэрээнд нэгдэн оржээ. Тиймээс үндэстний хууль тогтоомжоо эдгээр олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх шаардлагатай.

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгалийн нөөц ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар явуулах үндсэн арга механизм нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-ний тогтолцоо юм.<sup>1</sup> Энэ тогтолцоо үр нөлөөтэй ажиллах эсэх нь түүний эрх зүйн зохицуулалтын боловсронгуй байдалтай холбоотой.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ, хуучин нэрээр)-аас Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг<sup>2</sup> боловсруулан сонирхогч талуудаас санал авахаар [www.met.gov.mn](http://www.met.gov.mn) цахим хуудсандаа нээлттэй байршуулжээ.

<sup>1</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллага Хөгжлийн Хөтөлбөр, 2020 он, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэх механизмын бүтээмжийн үнэлгээ, 6 дахь тал, УБ;

<sup>2</sup> <https://met.gov.mn/documents/erh-z-jn-akt-t-s-l?sort=date&order=desc>



Б.ЭНХЦЭЦЭГ

Хуульч, өмгөөлөгч. Эрх зүйн бакалавр зэрэгтэй.

Байгаль орчин, уул уурхай, нийтийн эрх ашиг, хүний эрхийн хамгааллын чиглэлээр судалгаа, нөлөөллийн ажил эрхэлдэг.

Тус хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэх үндсэн зорилгоос ухарсан, одоогийн зохицуулалтыг сулруулсан, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний шаардлагад нийцэхгүй зохицуулалтууд тусгагдсан байна. Тэрчлэн хуулийн төсөлтэй хамт түүний үзэл баримтлалыг нийтлээгүйгээс хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага, ямар өөрчлөлт оруулж, ямар үр дүн хүлээж буй нь ойлгомжгүй байна.

## НӨХЦӨЛ БАЙДАЛ

Манай улсын эдийн засаг нь уул уурхайгаас хэт хамааралтай буюу 2023 оны байдлаар төсвийн нийт орлогын 29.9 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 70.7 хувийг олборлох салбар дангаар бүрдүүлж байна.<sup>3</sup> Үүнийг дагаад төрөөс ашигт малтмалын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх бодлогыг баримталж буй. Гэтэл олборлох салбар нь усны нөөц, агаарын чанарт нөлөөлж, газрын доройтол, цөлжилтийг нэмэгдүүлэх, химийн хортой, аюултай хог хаягдлыг бий болгох, биологийн олон янз байдлыг хомсдолд оруулах зэрэг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө ихтэйгээс гадна иргэдийн амьдралын хэмнэл, эрүүл мэнд, амьжиргаа болоод соёлын өвд ч эрсдэл бий болгодог.<sup>4</sup> Энэ тухай Хүний эрх, хөгжлийн төлөөх Азийн Форум (Форум-Ази), Хүний эрх хөгжил төв ТББ-ын хамтарсан судалгаанд “тусгай зөвшөөрөл олгох үйл явц улам хялбар болсноор, малчдын бэлчээрийн газар нутаг багасах, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс нэмэгдэж, амьдралын хэв маяг нь өөрчлөгдөх нөхцөл болж байна” гэжээ.<sup>5</sup> Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрх, ялангуяа малчдын амьдралд үзүүлэх нөлөөллийн талаар Хүний Эрхийн Үндэсний Комисс, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран гаргасан “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас хүний

Иймд энэхүү шинжилгээгээр хуулийн төслийг байгаль орчны чиглэлээрх Монгол Улсын олон улсын гэрээний нөхцөл, шаардлагатай харьцуулан шинжилж, нийцлийг тодорхойлохыг зорилоо. Ингэхдээ БОНБУ-нд иргэдийн мэдэх эрх, олон нийтийн хяналт, оролцоог хангахтай холбоотой зохицуулалтыг онцгойлон анхаарсан болно.

эрхэд үзүүлэх нөлөө”<sup>6</sup> НҮБ-ын Хүүхдийн сангийн “Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөөлөл”<sup>7</sup> болон Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн “Малчдын амьдралд уул уурхайн үзүүлэх нөлөө”<sup>8</sup> зэрэг судалгааны тайланд дурдагдсан хүний эрхийн зөрчил, байгаль орчныг дордуулж буй нөхцөл байдлууд сайжрахгүй хэвээр байна.

Иймд үйлдвэрлэл, тэр дундаа уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБУтХ)-ийн хэрэгжилтийг сайжруулах шаардлага тулгамдаж байна. Энэ талаар 2022 онд УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээний тайланд<sup>9</sup> “БОНБУтХ-ийн хэрэгжилтийн явц зохих түвшинд хэрэгжиж байгаа хэдий ч хуулийн зарим зохицуулалтын хувьд төсөв, санхүү, хүний нөөцийн чадавх, салбар хоорондын уялдаа, зохион байгуулалтаас шалтгаалан хангалттай түвшинд хэрэгжихгүй байна” гэж дүгнэжээ. Энэхүү дүгнэлтээ 14 асуудлаар нарийвчлан тодорхойлсноос БОНБУ-ний процесс дахь иргэд, олон нийтийн оролцоотой

<sup>3</sup> Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл /2023 оны I-XII сар/ УБ. 2024 он. 1-6 дахь тал;

<sup>4</sup> Н.Баярсайхан. Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг, гарын авлага, УБ. 2024 он. 13-14 дэх тал;

<sup>5</sup> Хүний эрх хөгжил төв ТББ. Монгол улсад уурхайн үйл ажиллагаа малчин иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлон үнэлэх судалгаа, УБ. 2023 он. 8 дахь тал;

<sup>6</sup> <https://www.uih.mn/sudalгаа/s/202>

<sup>7</sup> [https://www.unicef.org/mongolia/media/841/file/УУЛ\\_УУРХАЙГААС\\_ҮҮДСЭН\\_ШИЛЖИЛТ\\_ХӨДӨЛГӨӨН,\\_ХҮҮХДЭД\\_ҮЗҮҮЛЭХ\\_НӨЛӨӨЛӨЛ.pdf](https://www.unicef.org/mongolia/media/841/file/УУЛ_УУРХАЙГААС_ҮҮДСЭН_ШИЛЖИЛТ_ХӨДӨЛГӨӨН,_ХҮҮХДЭД_ҮЗҮҮЛЭХ_НӨЛӨӨЛӨЛ.pdf)

<sup>8</sup> [file:///C:/Users/HP/Downloads/MJAAE-2022-2+Tsetsegjargal%20\(3\).pdf](file:///C:/Users/HP/Downloads/MJAAE-2022-2+Tsetsegjargal%20(3).pdf)

<sup>9</sup> Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайлан, 2022 он, <https://www.parliament.mn/nn/16729/>

холбоотой дараах асуудлыг онцолжээ. Үүнд:

1. Хяналт шалгалтыг олон давтамжтай хийдэггүй,
2. БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмын хэрэгжилт хангалтгүй, хуулийн үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилго хангагдаагүй,
3. БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг зохион байгуулахад холбогдох талууд хэрхэн хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх зэрэг талуудын эрх үүргийг тодорхой болгосон эрх зүйн зохицуулалтгүй,
4. Олон нийтийн оролцоог хангах, бодит

хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хяналт тавих бодлого, зохион байгуулалтгүй,

5. Олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны хэлбэрүүд тодорхой бус зэрэг болно.

Харин БОАЖЯ-ны боловсруулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд олон нийтийн оролцооны цар хүрээг хумих, ач холбогдлыг бууруулах эрсдэлтэй зохицуулалтууд нэлээд тусжээ.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

Манай улс байгаль орчны чиглэлээр НҮБ болон олон улсын дараах 12 гэрээ конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан байна.<sup>10</sup> Үүнд:

### Биологийн олон янз байдлын чиглэлээр:

- а. Биологийн олон янз байдлын тухай конвенц<sup>11</sup>
  - Биологийн олон янз байдлын тухай конвенцын Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протокол;
  - Биоаюулгүй байдлын тухай Картеганы протокол;
  - Биоаюулгүй байдлын Картагены протоколын Хариуцлага ба хохиролгүй болгох тухай Нагоя-Куала Лумпурын нэмэлт протокол;
- б. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай Боннын конвенц<sup>12</sup>
- в. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг

газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенц<sup>13</sup>

- г. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц<sup>14</sup>
- д. Халим агнуурыг зохицуулах олон улсын конвенц<sup>15</sup>

### Химийн бодисын чиглэлээр:

- е. Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц<sup>16</sup>
- ж. Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц<sup>17</sup>
- з. Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц<sup>18</sup>

<sup>10</sup> Монгол Улсын олон улсын гэрээний дэлгэрэнгүй жагсаалт <https://legalinfo.mn/mn/detail?lawId=200006>

<sup>11</sup> Биологийн олон янз байдлын тухай конвенц, 1994 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1228>

<sup>12</sup> Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай Бонны конвенц, 1994 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10700>

<sup>13</sup> Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенц, 1972 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10702>

<sup>14</sup> Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, 1974 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10701>

<sup>15</sup> Халим агнуурыг зохицуулах олон улсын конвенц, 1947 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10703>

<sup>16</sup> Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц, 1990 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10705>

<sup>17</sup> Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц, 2010 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10707>

<sup>18</sup> Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц, 1998 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10706>

и. Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц<sup>19</sup>

#### Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр:

- к. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенц<sup>20</sup>
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Киотогийн протокол;
  - Парисын хэлэлцээр;

#### Агаар мандлыг хамгаалах чиглэлээр:

- л. Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц<sup>21</sup>
- Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протокол;

#### Цөлжилт, газрын доройтлын чиглэлээр:

Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенц<sup>22</sup>

Эдгээр гэрээн дэх иргэдийн мэдэх эрх, олон нийтийн хяналт, оролцоог хангахтай холбоотой зохицуулалт, тэдгээрийг Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар энэхүү тайлангийн дараагийн хэсэгт авч үзнэ.

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

### Хуулийн төсөлд тусгагдсан иргэдийн мэдэх эрх, олон нийтийн хяналт, оролцоотой холбоотой заалтууд, болзошгүй үр дагавар

Хуулийн төслийн заалт/Агуулга		Болзошгүй үр дагавар
<b>Дүгнэлт:</b> БОНБУ зайлшгүй байх, тогтмол хугацаанд шинэчлэх, мэргэжлийн түвшинд чанартай хийх талаар хангалттай шаардлага тавиагүй нь БОНБУ-ний үр нөлөөг бууруулах эрсдэлтэй.		
6.7	Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээ эсвэл тодорхойлолтыг тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн цар хүрээнд хамааран боловсруулах ба ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан нөлөөллийн үнэлгээний журмаар батална.	Төслүүдийг тодорхойгүй нөхцөлөөр ангилж, зарим төсөлд үнэлгээ хийх шаардлагагүй, заримд нь зөвхөн талуудын хүсэлтээр хийхээр тусгасан нь БОНБУ зайлшгүй байх шаардлагыг сулруулж байна.
6.11.	Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг тухайн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хэмжээнд хийлгэх хүсэлтийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн засаг дарга байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болох ба шийдвэрийг энэ хуулийн 6.3-д заасны дагуу гаргана.	
7.3	Төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээ, эсхүл тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.	
20.3	Энэ хуулийн 7.7-д заасан нөлөөллийн үнэлгээний журам, ангилалд заагаагүй аливаа төсөлд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ шаардахгүй.	

<sup>19</sup> Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц, 2015 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11044>

<sup>20</sup> Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенц, 1993 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10695>

<sup>21</sup> Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц, 1985 он, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10698>

<sup>22</sup> Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенц, 1994 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10699>

7.11	Тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хамрах цар хүрээ нь өндөр байх боломжтой төслийн үйл ажиллагааг "их", хязгаарлагдмал байх боломжтой төслийн үйл ажиллагааг "дунд", доогуур байх боломжтой төслийн үйл ажиллагааг "бага" гэж тус тус ангилна.	<i>Бага ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй, үнэлгээг анх удаа хийхээс бусад тохиолдолд орон нутгийн иргэдэд танилцуулахгүй гэсэн нь үнэлгээний ач холбогдлыг сулруулж, олон нийтийн оролцоог үгүйсгэсэн байна. Ингэснээр иргэд үнэлгээний тайлангаар дамжуулан төслийн орон нутагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлж, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд оролцох боломжийг хязгаарлаж байна.</i>
7.12	Их ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд 5 жил, дунд ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд 10 жил тутамд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд бага ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд энэ хуулийн 7.12-д заасан нөхцөл үүсээгүй тохиолдолд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй.	
7.14	Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.12-т заасан хугацааг харгалзахгүй нэмэлт тодотгол хийх хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагад гаргана.	
14.1.3	Энэ хуулийн 8.4.6-д заасан төсөл уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг төсөл эхлэхээс өмнө суурь түвшинд, төсөл хэрэгжсэнээс хойш 5 жил тутамд, төсөл хаагдахаас 3-аас доошгүй жилийн өмнө хаалтын төлөвлөгөөг тус тус боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх.	
6.8	Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолтыг төсөл хэрэгжүүлэгч хариуцан, байгаль орчны мэргэжилтэн, судлаачдын оролцоотой боловсруулна.	<i>Байгаль орчны нөхцөл байдал, төслийн нөлөөгөөр үүсэх эрсдэлийг мэргэшсэн шинжээч, мэргэжилтний оролцоотойгоор нарийвчлан тодорхойлох шаардлагыг тусгаагүй. Энэ нь үнэлгээний тайлан стандартад нийцсэн бөгөөд үнэн зөв, үндэслэлтэй байх нөхцөлийг бууруулж, байгаль орчны эрсдэлийг нэмэгдүүлнэ.</i>
7.10.	Холбогдох хууль тогтоомжоор тухайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг баталгаажуулах эрх бүхий байгууллага тодорхойгүй бол төсөл хэрэгжүүлэгч байгууллага өөрөө баталгаажуулж ирүүлнэ.	
7.6.	Улсын хэмжээнд үнэлгээний шинжээч болон тэдгээрийн үйл ажиллагааг удирдан зохицуулах ерөнхий шинжээчээр байгаль орчны чиглэлээр 8-аас дээш жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно.	
<b>Дүгнэлт:</b> <i>Иргэдийн мэдээлэл авах эрхэд халдаж, мэдээллийн хүртээмжийг хязгаарласан.</i>		
10.1.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална.	<i>Иргэдэд мэдээллийг зөвхөн цахим хэлбэрээр хүргэхээр байгаа нь орон нутгийн иргэдийн мэдээлэл авах боломжийг хязгаарлахаар байна. Энэ нь мэдээллийн хүртээмжгүй байдлыг улам даамжруулж, зорилтот бүлгийн иргэд мэдээллээс хоцроход хүргэнэ.</i>



14.1.5.	Иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.	<p><i>БОНБУ-ний мэдээлэл нь иргэдэд нээлттэй биш, заавал хүсэлт гаргасны үндсэн дээр авч танилцах, ингэхдээ зөвхөн хуулиар тодорхойлсон зарим мэдээллийг л авч болохоор заасан нь Үндсэн хуулийн 6.2 дахь заалтаар баталгаажсан иргэдийн мэдэх эрх, Нийтийн мэдээллийн илт тод байдлын тухай болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарчим, зохицуулалтад харшилж байна.</i></p>
18.5.	Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.	
7.15	Энэ хуулийн 7.12-т үүссэн нөхцөлийн дагуу хийж байгаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад мөн энэ хуулийн 7.3.1, 8.4.8-д заасан санал, хэлэлцүүлгийн тайланг шинээр авч ирүүлэхийг шаардахгүй.	
18.4.	Тухайн төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах шаардлагатай байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийн ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан журмаар батална.	
8.4.8.	Энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хороо иргэдэд хийсэн танилцуулгын тайлан;	<p><i>Нөлөөллийн үнэлгээний мэдээллийг зөвхөн тухайн төсөл хэрэгжих “баг, хорооны иргэд” авч болохоор заасан нь олон нийт, төслийн дам нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэдийн мэдээлэл авах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх эрсдэлийг бий болгож байна.</i></p>
10.5.	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулна.	
<b>Дүгнэлт:</b> <i>БОНБУ-н дэх олон нийтийн оролцоог хумьж, ач холбогдлыг бууруулсан.</i>		
7.7.	Нөлөөллийн үнэлгээний журам, ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, ангилалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадалгаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, дүйцүүлэн хамгаалал, нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана.	<p><i>БОНБУ дэх олон нийтийн оролцоог бие даасан журмаар тусгайлан зохицуулж байсныг өөрчилж, өөр бусад журамд нэгтгэн оруулахаар заасан нь олон нийтийн оролцооны ач холбогдлыг бүдгэрүүлж, хэрэгжилтийг бууруулах эрсдэлтэй. Хуулийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээгээр илрүүлсэн олон нийтийн оролцоонд тулгарч байгаа асуудлуудыг улам дордуулах эрсдэлтэй.</i></p>
18.4.	Тухайн төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах шаардлагатай байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийн ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан журмаар батална.	

8.4.8.	Энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хороо иргэдэд хийсэн танилцуулгын тайлан;	
10.5.	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулна.	
14.1.	Стратегийн үнэлгээнд хамрагдах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч дараах үүрэг хүлээнэ: 14.1.2. байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг төсөл хэрэгжих баг, хорооны иргэд, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах;	
18.3.	Стратегийн үнэлгээнд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон эсхүл бичгээр санал авна.	<p><i>Төслийн нөлөөлөлд өртөх талуудыг үнэлгээгээр тодорхойлдог жишиг, шаардлагыг үл хайхран “зөвхөн “тухайн баг, хороо”-ны иргэд хэмээн хуулиар урьдчилан тодорхойлох нь өрөөсгөл юм. Аливаа төслийн нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ нь тухайн төслийн болон орон нутгийн онцлогоос хамаарч ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл, нөлөөллийн хамрах хүрээ, газар нутаг, түүнд өртөх талуудыг зөвхөн тухайн төсөлд тусгайлан үнэлгээ хийх замаар л тодорхойлох ёстой.</i></p> <p><i>Харин хуулийн төсөлд өртөх талуудыг “тухайн баг, хороо”-ны иргэд хэмээн заасан нь нөлөөлөлд өртөх иргэд болон бусад талуудын шийдвэр гаргах үйл явц дахь оролцоо, эрх ашиг сонирхлоо хамгаалах боломжийг хязгаарлах эрсдэлтэй.</i></p>
6.10.	Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны газар хариуцна.	<p><i>Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг нэгдмэл байдлаар зохион байгуулж, иргэдэд тайлагнах шаардлагыг тусгаагүй, үүрэг хариуцлагыг задлан тархаах нь иргэдийн мэдээлэл авах, хяналт тавих боломжийг хязгаарлаж, байгаль орчин, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд эрсдэл учруулж болзошгүй.</i></p>

Байгаль орчны чиглэлээрх Монгол Улсын олон улсын гэрээ: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нийцэл

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>1. Байгаль орчны асуудлыг өргөн хүрээнд авч үзэх талаар</b></p> <p><b>Биологийн олон янз байдлын тухай конвенц</b> Улсууд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, олон улсын эрх зүйн дагуу нөөц баялгаа ашиглах бие даасан эрх эдлэх ба үндэсний хууль тогтоомжийнхоо хүрээнд, мөн түүний хяналтад явуулах энэ талын үйл ажиллагаа нь үндэсний хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнээс гадна орших бусад улс орон, бүс нутгийн хүрээлэн буй орчинд хор хохирол учруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.<sup>23</sup></p>	<p>6.7. Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээ эсвэл тодорхойлолтыг тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн цар хүрээг хамааран боловсруулах ба ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан нөлөөллийн үнэлгээний журмаар батална.</p> <p>8.4. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана: <b>8.4.8.энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хороо иргэдэд хийсэн танилцуулгын тайлан;</b> 10.5. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд <b>өртөх баг, хорооны иргэдэд</b> танилцуулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Байгаль орчинд учирч болох эрсдэл, сөрөг нөлөөлөл нь зөвхөн аль нэг нутаг дэвсгэрээр орон, тодорхой газар нутгийн асуудал бус хөрш зэргэлдээ улс, бүс нутаг, дэлхий нийт төдийгүй хүн төрөлхтөний ирээдүй хойчид ч хамаатай билээ. Иймд эдгээр гэрээнд нэгдсэн улс орнуудын хувьд төслийн нөлөөллийг өргөн хүрээнд авч үзэж, тодорхойлох үүрэгтэй.</p>	<p>Хүний оролцоотой аливаа үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл нь зөвхөн аль нэг нутаг дэвсгэрээр хязгаарлагдана гэж үзэх боломжгүй бөгөөд агаар, ус, хөрс, уур амьсгал, озоны давхарга зэрэг ямар нэг хязгаар тогтоох боломжгүй асуудлуудыг ч хамардаг. Иймд эдгээр конвенцын хүрээнд улс орнуудад нөлөөлөлд өртөж болох талуудыг өргөн хүрээнд авч үзэхийг зөвлөдөг. Харин хуулийн төсөлд үйлдвэр, үйлчилгээний аливаа төслийн нөлөөлөл, түүнд өртөгч талуудыг зөвхөн төсөл хэрэгжих баг хорооны нутаг дэвсгэр, түүний иргэд байх мэтээр хязгаарласан нь олон улсын гэрээний шаардлагад нийцэхгүй байна.</p>
<p><b>Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц</b> Энэхүү конвенцын Талууд, хүний үйл ажиллагааны улмаас озоны үе давхарга өөрчлөгдөхөөс хамгаалах арга хэмжээ нь олон улсын хамтын ажиллагаа, олон улсын түвшинд зохицуулсан үйл ажиллагааг шаардаж байгаа, мөн шинжлэх ухаан, техникийн зохих үндэслэлд тулгуурласан байх ёстойг ухамсарлан, энэхүү Конвенцын холбогдох Протоколын заалтын дагуу озоны үе давхаргын төлөв байдлыг өөрчлөх юм уу өөрчлөхүйц үйл ажиллагааны улмаас буй болсон эсхүл буй болж болзошгүй сөрөг үр дагавраас хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах талаар зохих арга хэмжээ авна.<sup>24</sup></p>			
<p><b>Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенц</b> Хэлэлцэн тохирогч талууд, Ган, цөлжилт нь өргөн хүрээтэй асуудал болж, дэлхийн нийт бүс нутагт нөлөөлж, түүнтэй тэмцэх, тэдгээрийн нөлөөллийг бууруулахад олон улсын хамтын нийгэмлэгийн хамтарсан үйл ажиллагаа шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч, ган, цөлжилтийн явцад үүсэх физик, биологи, нийгэм эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авна.<sup>25</sup></p>			

<sup>23</sup> Биологийн олон янз байдлын тухай конвенцын 3 дугаар зүйл;

<sup>24</sup> Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенцын 2 дугаар зүйл. Ерөнхий үүрэг 2.1 дэх хэсэг;

<sup>25</sup> Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенцийн 4 дүгээр зүйл. Нийтлэг үүрэг, 4.2.а дахь хэсэг;



Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Усны шувууд улирлаар хил дамнан нүүдэллэх учир түүнийг олон улсын нөөц баялгийн нэгэн адил үзэх ёстойг хүлээн зөвшөөрч, Ус, намгархаг газар, түүний ургамал ба амьтны аймгийг хамгаалах алсын хараатай үндэсний бодлого нь олон улсын зохицуулалттай үйл ажиллагаатай хослон хэрэгжинэ гэдэгт итгэл төгс байна.</p>			
<p><b>Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Зэрлэг амьтан, ургамлын аймаг нь олон төрөл зүйл, үзэсгэлэнт сайхан болоод янз бүрийн хэлбэр төрхөөрөө энэ ертөнцийн байгалийн тогтолцооны орлуулшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийг хамгаалах ёстой.</p>			
<p><b>Халим агнуурыг зохицуулах олон улсын конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Байгалийн баялаг болох халимын сүргийг хойч үеийнхэндээ хамгаалан үлдээх, дэлхийн улс орнуудын ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрнө.</p>			
<b>2. Хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хөнөөлт нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдлыг нэн тэргүүнд авч үзэх</b>			
<p><b>Биологийн олон янз байдлын тухай конвенц</b></p> <p>Улсууд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, олон улсын эрх зүйн дагуу нөөц баялгаа ашиглах бие даасан эрх эдлэхдээ биологийн нөөцийг ашиглах салбарт олон янз байдалд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг арилгах, багасгахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.<sup>26</sup></p>	<p>3.1.5. "хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ" гэж тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;</p>	<p>Конвенцод нэгдсэн улс орнууд өөрийн улсын онцлог, эдийн засгийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан байгалийн нөөц баялгаа ашиглах бүрэн эрхтэй боловч байгаль орчны тэнцвэрт байдал, хүний эрүүл мэндийн асуудлыг эн тэргүүнд авч үзэх үүрэгтэй.</p>	

<sup>26</sup> Биологийн олон янз байдлын тухай конвенцын 10 дугаар зүйл. Биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсгийг тогтвортой ашиглах;

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Улс орнууд хүний эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах талаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой бөгөөд олон улсын эрх зүйн дагуу хариуцлага хүлээнэ гэдгээ баталж, аюултай болон бусад хог хаягдлыг ашиглахад оролцож буй хүмүүсийг уг хаягдлаас үүсэх хортой нөлөөллөөс хамгаалах бүхий л арга хэмжээ авах ба хэрэв ямар нэг хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хор уршгийг багасгах арга хэмжээ авна.<sup>27</sup></p>	<p>3.1.6. "байгаль орчны нөлөөллийн үнэлгээ" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад <b>байгаль орчин, нийгэмд</b> учруулж болзошгүй нөлөөлөл, <b>цар хүрээ</b>, үр дагаврыг <b>төслийн үе шатуудад</b> урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;</p> <p><b>6.11. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг тухайн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хэмжээнд хийлгэх хүсэлтийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн засаг дарга байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болох ба шийдвэрийг энэ хуулийн 6.3-д заасны дагуу гаргана.</b></p> <p>7.4. Шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, байгалийн нөөц ашиглах төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг үнэлгээний шинжээч ажлын 14 хоногт багтаан хийж дараах дүгнэлт гаргана:</p> <p>7.4.2. төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх;</p>		<p>Харин хуулийн төсөлд хөгжлийн болон үйлдвэрлэл, үйлчилгээний төслүүдийг тодорхой нөхцөлөөр ангилж, тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд тодотгол хийхгүй байхаар, мөн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг харгалзан нарийвчилсан үнэлгээ хийхгүй байж болохоор заасан нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт нийцэхгүй байна.</p>
<p><b>Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Бүх улс орнууд, ялангуяа хөгжиж буй орнууд нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлөө хангахын тулд байгалийн нөөцөө ашиглах шаардлагатайг нотолж, энэ үйлстээ хөгжиж буй орнуудад хүлэмжийн хийн хаягдалтай тэмцэх, өндөр үр ашигтай эрчим хүчийг хөгжүүлэхэд эдийн засаг, нийгмийн үүднээс хамгийн үр ашигтай шинэ технологи хэрэглэх хэрэгтэйг хүлээн зөвшөөрч, Талууд хүн төрөлхтөний өнөөгийн ба ирээдүй үеийнхний сайн сайхны тусын тулд өөр өөрсдийн болоод бүх нийтийн үүрэг хариуцлагадаа нийцүүлэн эрх тэгш байдлын үндсэн дээр уур амьсгалын тогтолцоог хамгаална.<sup>28</sup></p>			

<sup>27</sup> Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцын 4 дүгээр зүйл. Ерөнхий үүрэг 4.2.с дэх хэсэг;

<sup>28</sup> Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенцын 3 дугаар зүйл. Зарчмууд, 3.1 дэх хэсэг;

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Улс орнууд НҮБ-ын Дүрэм, олон улсын эрх зүйн зарчмуудад нийцүүлэн өөрсдийн нөөц баялгаа хүрээлэн буй орчны болон хөгжлийн бодлогынхоо дагуу ашиглах бүрэн эрхтэй бөгөөд тэрхүү эрхээ эдлэхдээ эрх хяналтынх нь дор явагдаж буй үйл ажиллагаа дотоодын хууль, эрх мэдлийн хүрээнээс гадна оршиж буй газар нутаг, бусад орны байгаль орчинд хор хохирол учруулахгүй байх хариуцлага хүлээхийг нотолж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг удаан задардаг органик бохирдуулагчаас хамгаалахад зорино.<sup>29</sup></p>	<p><b>7.11. Тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хамрах цар хүрээ нь өндөр байх боломжтой төслийн үйл ажиллагааг "их", хязгаарлагдмал байх боломжтой төслийн үйл ажиллагааг "дунд", доогуур байх боломжтой төслийн үйл ажиллагааг "бага" гэж тус тус ангилна.</b></p> <p><b>7.12. Их ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд 5 жил, дунд ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд 10 жил тутамд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд бага ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд орчны нөлөөллийн үнэлгээнд энэ хуулийн 7.12-д заасан нөхцөл үүсээгүй тохиолдолд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй.</b></p> <p><b>18.4. Тухайн төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах шаардлагатай байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийн ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан журмаар батална.</b></p>		

<sup>29</sup> Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцын 1 дүгээр зүйл зорилго;

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаар</b></p> <p><b>Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Удаан задардаг органик бохирдуулагчаас нөхөн үржихүйн эрүүл мэндэд үзүүлдэг нөлөөллийг бууруулах талаар судалгаа хийнэ, судлах, боловсруулах, шинжилгээ хийх талаар энэхүү заалтад дурдсан үйл ажиллагааны үр дүнтэй цаг тухайд нь танилцах боломжийг олон нийтэд байнга олгоно.<sup>30</sup></p> <p>Тал бүр дараах арга хэмжээг авахад бололцооныхоо хэрээр дэмжиж тусална. Үүнд: (б) 9 дүгээр зүйлийн 5 дугаар заалтыг харгалзан удаан задардаг органик бохирдуулагчийн тухай байгаа бүхий л мэдээллийг олон нийтэд хүргэх; (в) удаан задардаг органик бохирдуулагчид, тэдгээрээс хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлдэг уршиг нөлөө болон тэдгээрийг орлуулах зүйлийн талаар танилцуулсан олон нийтийн сурталчилгааны болон сургалтын хөтөлбөрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, боловсрол дутмаг хүмүүст зориулан боловсруулж хэрэгжүүлэх; (г) удаан задардаг органик бохирдуулагчид, тэдгээрээс хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж буй уршиг нөлөөний талаар хэлэлцэх, холбогдох арга хэмжээг боловсруулахад олон нийтийг оролцуулах. Тухайлбал, энэхүү Конвенцыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжийг олгоно.<sup>31</sup></p>	<p><b>8.4.8.</b> энэ Энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хорооны иргэдэд хийсэн танилцуулгын тайлан;</p> <p><b>10.1.</b> Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална.</p> <p><b>10.5.</b> Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулна.</p> <p><b>14.1.5.</b> Иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.</p>	<p>Улс орон бүр гэрээгээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд байгаль орчин, хүнд үзүүлж буй хор хөнөөл, түүний эсрэг авч байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг өргөн хүрээнд нээлттэй байлгаж, холбогдох талуудтай тогтмол хугацаанд, шуурхай солилцож байгаа илэрхийлсэн болно. Байгаль орчны нөхцөл байдал, учирч болох эрсдэл, сөрөг нөлөөллийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хязгаарлах нь дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа байгаль орчны асуудлуудаас урьдчилан сэргийлэх боломжийг хязгаарлах, хугацаа алдах, эрсдэлийг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавартай.</p>	<p>Хуулийн төсөлд нөлөөлөлд өртөж болзошгүй этгээдийг “баг, хорооны иргэд” хэмээн явцуу хүрээнд тодорхойлж, зөвхөн тэдэнд тайлан, мэдээлэл танилцуулахаар заасан нь учир дутагдалтай байна. Түүнчлэн иргэд мэдээлэлтэй танилцахыг хүсвэл төсөл хэрэгжүүлэгч болон засаг даргад хүсэлт гаргах, БОНБУ-ний тайлангийн хэвлэмэл хувийг зөвхөн үнэлгээ хийсэн байгууллага хадгалж байх зохицуулалт нь мэдээллийн хүртээмжийг хязгаарласан шинжтэй байна. Иймд иргэдийн мэдээлэл авах эрхийг хязгаарласан дараах заалтыг хуулийн төслөөс хасах нь зүйтэй. Үүнд:</p> <p>а. Иргэд зөвхөн цахим хэлбэрээр мэдээлэл авах боломжтой байх хязгаарлалт, БОНБУ-ний мэдээлэлтэй иргэд заавал хүсэлт гаргаж танилцах зохицуулалт,</p>

<sup>30</sup> Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцын 11 дүгээр зүйл. Судалгаа, шинжилгээ, 11.г, 11.д дэх хэсэг;

<sup>31</sup> Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцын 10 дугаар зүйл. Олон нийтийн мэдээлэл, сурталчилгаа, боловсрол;

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц</b> Энэхүү конвенцод оролцогч Талууд: Мөнгөн ус нь агаар мандлаар хол зайд дамждаг, хүний хүчин зүйлийн нөлөөгөөр байгаль орчинд ялгарч, цаашид задрахгүйгээр үлддэг, экосистемд биохуримтлал үүсгэх чадвартай, хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үлэмж сөрөг нөлөө үзүүлдэг чанараараа дэлхий нийтээр сэтгэл зовниход хүргэж буй химийн бодис болохыг хүлээн зөвшөөрч, Талууд нь өөрийн нутаг дэвсгэр дээрх хавсралт Б-д жагсаалтаар орсон мөнгөн ус эсхүл түүний нэгдлийг ашигладаг үйлдвэрийн тоо, төрөл, эдгээр үйлдвэрт ашигласан мөнгөн ус эсхүл түүний нэгдлийн жилийн зарцуулалтын талаарх мэдээллийг гарган конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн дотор Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлэх. Нарийн бичгийн дарга нарын газар уг мэдээллийг нь олон нийтэд нээлттэй байлгана.<sup>32</sup></p>	<p><b>18.4.</b> Тухайн төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах шаардлагатай байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийн ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан журмаар батална. <b>18.5.</b> Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.</p>	<p>Засгийн газар нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу “нөлөөлөлд өртөж болзошгүй” талуудад мэдээллийг шуурхай хүргэх, нээлттэй байлгах үүрэгтэй.</p>	<p>с. Зарим мэдээлэлтэй иргэд огт танилцах шаардлагагүй гэсэн зохицуулалт, d. Зөвхөн төсөл хэрэгжих талбайн “баг, хорооны иргэд” мэдээлэл авах боломжтой гэсэн зохицуулалт.</p>
<p><b>Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенц</b> Хэлэлцэн тохирогч талууд: Уур амьсгалын өөрчлөлтийн дэлхий нийтийг хамарсан шинж чанар нь улс орнуудын хамгийн өргөн хүрээтэй хамтын ажиллагааг шаардаж байгаагийн дээр үүнд улс бүр олон улсын нийтлэг болон өөрсдийн бодит боломж, нийгэм, эдийн засгийн нөхцөлөөс үүдэн гарах ялгавартай хариуцлагаа ухамсарлан үр бүтээлтэй оролцохын чухлыг хүлээн зөвшөөрч, Уур амьсгалын тогтолцоо болон уур амьсгалын өөрчлөлт, тэрчлэн хариу арга хэмжээний янз бүрийн стратегийн бодлогын нийгэм- эдийн засгийн үр дагавартай холбоотой шинжлэх ухаан, техник, технологи, нийгэм,эдийн засгийн болоод хууль эрх зүйн мэдээллийг бүрэн хэмжээгээр, ил шуурхай солилцох талаар хамтран ажиллана, дэмжлэг үзүүлнэ.<sup>33</sup></p>			

<sup>32</sup> Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын 5 дугаар зүйл. Мөнгөн ус эсхүл түүний нэгдлийг ашигладаг Үйлдвэрлэлийн процесс, 5.5.(в) дэх хэсэг;

<sup>33</sup> Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенцын 4 дүгээр зүйл. Үүрэг, амлалт 4-ж дэх хэсэг;



Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>4. Иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох чиглэлээр</b></p> <p><b>Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц</b> Энэхүү конвенцод оролцогч Талууд: Мөнгөн усны нөлөөнд хүн амын эмзэг хэсэг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, тэднээр дамжуулан ирээдүй үе өртөж буйг, ялангуяа хөгжиж буй орнуудад эрүүл мэндийн асуудал үүсэж буйг ойлгон ухамсарлаж, мөнгөн ус, түүний нэгдлийн өртөлтөөс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар холбогдох засгийн газар хоорондын байгууллага болон төрийн бус байгууллагатай хамтран боловсрол олгох, сургалт явуулах, олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх, шаардлагатай тохиолдолд эмзэг бүлгийн хүмүүстэй хамтран ажиллана.<sup>34</sup></p>	<p>7.7. Нөлөөллийн үнэлгээний журам, ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, ангилалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадалгаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, дүйцүүлэн хамгаалал, нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана.</p> <p>18.4. Тухайн төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах шаардлагатай байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийн ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан журмаар батална.</p> <p>8.4.8. энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хороо иргэдэд хийсэн танилцуулгын тайлан;</p> <p>10.5. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Төслийн сөрөг нөлөөлөлд нэн түрүүнд нутгийн уугуул иргэд, тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхдүүд өртдөгийг хүлээн зөвшөөрч, тэднийг шийдвэр гаргахад оролцуулах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх нь чухал болохыг олон улсын гэрээнд заасан байдаг. Ингэж оролцуулахдаа мэдээлэл хүргэх төдийгөөр хязгаарлахгүйгээр мэдээлэл авах, түүний мөрөөр идэвхтэй арга хэмжээ авах (хэлэлцүүлэг, уулзалт, хүсэлт, шаардлага тавих г.м), шийдвэрт нөлөөлөх зэрэг боломжийг бүрдүүлэх үүрэгтэй.</p>	<p>Хуулийн төсөлд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг зөвхөн төсөл хэрэгжих баг, хорооны иргэдэд танилцуулахаар заасан ба стратегийн үнэлгээнд иргэд цахим хэлбэрээр санал өгөх боломжийг хассан, мөн мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хязгаарлаж, нөлөөллийн үнэлгээний мэдээлэлтэй танилцахад заавал хүсэлт гаргахаар тусгажээ. Үүнээс гадна иргэдийн хяналтыг бий болгох зохицуулалт тусгаагүй бөгөөд бодитой оролцоо буюу шийдвэрт нөлөөлөх боломжийг бүрдүүлээгүй байна.</p> <p>Иймд БОНБУ-н дэх олон нийтийн оролцоог хумих, ач холбогдлыг нь бууруулсан дараах зохицуулалтыг эргэн харж, засах нь зүйтэй. Үүнд:</p> <p>а. БОНБУ дэх олон нийтийн оролцоог бие даасан журмаар зохицуулж байсныг больж, өөр журамд нэгтгэсэн.</p>
<p><b>Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц</b> Хэлэлцэн тохирогч талууд: Удаан задардаг бохирдуулагчдад өртсөний улмаас учрах сөрөг үр дагавар нь голдуу хөгжиж буй орнуудын хүн ам, ялангуяа эмэгтэйчүүдэд, тэднээр дамжин хойч үед нөлөөлөх болж байгааг харгалзан, Талууд Конвенцыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, биелүүлэх, шинэчлэхэд бие биедээ туслалцаа үзүүлэх үүднээс шууд буюу дэлхий нийтийн, бүсийн, Дэд бүсийн байгууллагуудаар дамжуулан хамтран ажиллах ба үндэсний холбогдох этгээдүүдтэй, түүний дотор эмэгтэйчүүдийн байгууллага, хүүхдийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагуудтай зөвлөлдөнө<sup>35</sup></p>			

<sup>34</sup> Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын 18 дугаар зүйл. Олон нийтийн мэдээлэл, мэдлэг, боловсрол, 18.1(б) дэх хэсэг;  
<sup>35</sup> Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцын 7 дугаар зүйл. Хэрэгжүүлэх төлөвлөгөө, 7.2 дах хэсэг.

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Ган, цөлжилтөд нэрвэгдсэн бүс нутаг, ялангуяа хөгжиж буй орнуудын орон нутгийн эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөллийг бууруулах бүх шатны үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бүрэн оролцоог хангахыг онцлон тэмдэглэж, орон нутаг, үндэсний болон бүс нутгийн түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийхэд нөөц ашиглагч нар түүний дотор төрийн бус байгууллагууд, орон нутгийн хүн ам, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, ялангуяа тариачид, малчид, тэдгээрийн төлөөллийн байгууллагуудыг оролцуулна. Энэ ажлын явцын талаар хяналтын болон ажлын тайланг тогтмол бэлтгэж байна.<sup>36</sup></p>	<p>14.1. Стратегийн үнэлгээнд хамрагдах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч дараах үүрэг хүлээнэ: 14.1.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг төсөл хэрэгжих баг, хорооны иргэд, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах;</p> <p>18.3. Стратегийн үнэлгээнд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон эсхүл бичгээр санал авна.</p> <p>6.10. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны газар хариуцна.</p>		<p>b. Иргэдийн оролцооны хэлбэрүүдийг хумьж, иргэд бодитоор оролцох боломжийг хязгаарласан.</p> <p>c. Иргэдийн хяналт тавих боломж, нөхцөлийг бүрдүүлээгүй.</p>
<p><b>Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Хүний эрүүл мэнд түүний дотор хэрэглэгчид, ажилчид болон хүрээлэн буй орчныг олон улсын хэмжээнд худалдаалж байгаа аюултай зарим химийн бодис болон пестицидийн үзүүлж болох хортой нөлөөллөөс хамгаалах шийдвэр төгс байгаагаар илэрхийлж, Конвенцын хүрээнд химийн бодисуудын талаар тэдгээрийн хор аюул, экологийн хор хөнөөл болон аюулгүйн мэдээллийг оруулсан судалгаа шинжилгээний, техникийн, эдийн засгийн болон хууль зүйн мэдээлэл солилцоно.<sup>37</sup></p>			

<sup>36</sup> Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенцын 4 дүгээр зүйл. Нийтлэг үүрэг, 4.2.а дахь хэсэг;

<sup>37</sup> Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенцын 14 дүгээр зүйл. Мэдээлэл солилцох, 14.1 дэх хэсэг;

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн иргэдэд түшиглэх асуудлаар	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>5. Байгаль орчныг хамгаалахад уламжлалыг хадгалах, Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт</b></p> <p><b>Биологийн олон янз байдлын тухай конвенц</b> Хэлэлцэн тохирогч улсууд: үндэснийхээ хууль тогтоомжийн дагуу биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглахад ач холбогдол бүхий амьдралын уламжлалт хэв шинжийг хадгалсан уугуул хүн ам, нутгийн хэсэг бүлэг хүмүүсийн мэдлэг, шинэлэг зүйл, амьдралын туршлагыг хүндэтгэн хамгаалж дэмжих, түүнийг тэдгээр хүмүүсийн оролцоотойгоор дэлгэрүүлж, хэрэглэх боломж олгох, мөн түүнчлэн тийм мэдлэг, шинэлэг зүйл, амьдралын туршлагыг хэрэглэснээр гарах үр ашгийг тэгш шударга зарчмаар хамтран ашиглах явдлыг дэмжих; биологийн нөөцийг ашиглах уламжлалт аргуудыг уг нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах шаардлагад нийцсэн зан заншлын дагуу хамгаалж, дэмжинэ.<sup>38</sup></p>	<p><b>Хуулийн төсөлд,</b> 5.2. Стратегийн үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллага, тухайн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, бие даасан шинжээч, мэргэжилтнүүдийн багийн оролцоотойгоор хийж тайлан гаргана. 6.2. Төлөв байдлын үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хийлгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан чиглэл гаргуулна. 6.10. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны газар хариуцна.</p>	<p>Нутгийн уугуул иргэдийн өвлөн уламжилж ирсэн байгаль хамгаалах арга нь байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалахад хамгийн үр дүнтэй байдаг. Иймд аливаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сөрөг нөлөөллийг нь бууруулахад нутгийн иргэдтэй хамтрах, тэдний санал, санаачилгыг хүндэтгэн дэмжих нь маш чухал болохыг гэрээний оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн болно.</p>	<p>Хуулийн төсөлд, нөлөөллийн үнэлгээ хийх болон тус нөлөөллийг бууруулах төлөвлөгөө боловсруулахад нутгийн иргэдтэй зөвшилцөх, түншлэх талаар ямар нэг зохицуулалт байхгүй байна.</p>
<p><b>Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенц</b> Хэлэлцэн тохирогч талууд: Энэхүү конвенцын зорилгод хүрэх, түүний заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд Талууд дор дурдсан зүйлийг удирдлага болгоно. Үүнд: а) Талууд нь цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шийдвэр гаргахдаа хүн ам, орон нутгийн үүсгэл санаачилгын байгууллагуудыг оролцуулж, улс үндэсний болон орон нутгийн үйл ажиллагааг тусалж дэмжих тааламжтай орчныг бий болгох нөхцөлийг хангах. в) Талууд нэрвэгдэж буй бүс нутгийн газрын байдал, үнэ цэнэ, усны нөөцийн хомсдол тэдгээрийг зүй зохистой ашиглах зэргийг илүү гүнзгий ойлгуулахын тулд засгийн газрын бүх түвшин, нийгмийн бүлгүүд, төрийн бүс байгууллагууд болон газар эзэмшигчдийн хоорондын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх.<sup>39</sup></p>			

<sup>38</sup> Биологийн олон янз байдлын тухай конвенцын 8 дугаар зүйл. In-situ хадгалах;

<sup>39</sup> Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенцийн 3 дугаар зүйл. Зарчим, 3.1 дэх хэсэг.

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
	<p>8.5. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжүүлэгчээс албан ёсоор санал авна.</p> <p>9.1. Төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгэр тогтоосон төсөл нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ.</p>		
<b>6. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг зайлшгүй бөгөөд мэргэжлийн түвшинд хийх асуудлаар</b>			
<p><b>Биологийн олон янз байдлын тухай конвенц</b> Хэлэлцэн тохирогч улсууд: Биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглахад сөрөг нөлөө үзүүлдэг болон үзүүлж болохуйц үйл явц, үйл ажиллагааны зэрэглэлийг тодорхойлж, түүний үр дагаварт дээжлэх болон бусад арга хэрэгслээр хяналт-шинжилгээ хийнэ.<sup>40</sup> Мөн тус конвенцод биологийн олон янз байдлыг сөрөг нөлөөллөөс сэрэмжлэх, нөлөөллийг багасгах зорилгоор өөрсдийн дэвшүүлсэн төслүүдэд экологийн экспертиз хийх журмыг нэвтрүүлэх ба шаардлагатай бол түүнд олон нийтийг оролцуулна; биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлж болох өөрсдийн бодлого, хөтөлбөрийн экологийн үр дагаврыг заавал тооцсон байх арга хэмжээ авна.<sup>41</sup></p>	<p>Хуулийн төсөлд:</p> <p><b>6.7.</b> Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээ эсвэл тодорхойлолтыг тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн цар хүрээнд хамааран боловсруулах ба ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан нөлөөллийн үнэлгээний журмаар батална.</p>	<p>Байгаль орчинд үзүүлэх хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг бууруулахад сайтар төлөвлөсөн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүх төрлийн төсөл, хөтөлбөрт байгаль орчны нөлөөллийн үнэлгээ заавал хийх,</li> </ul>	<p>Хуулийн төсөл нь, нөлөөллийн үнэлгээг зайлшгүй хийх, тогтмол хугацаанд хийх, мэргэжлийн түвшинд хийх талаар зохицуулалт хангалттай биш байгаад анхаарч, БОНБУ-ний ач холбогдлыг сайжруулахад анхаарах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий үнэлгээнд үндэслэн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагагүй гэж дүгнэлт гаргах,</li> </ul>

<sup>40</sup> Биологийн олон янз байдлын тухай конвенцын 7 дугаар зүйл. Тодорхойлох болон хяналт, шинжилгээ хийх

<sup>41</sup> Биологийн олон янз байдлын тухай конвенцын 14 дүгээр зүйл. Нөлөөллийг үнэлэх, сөрөг үр дагаврыг багасгах

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Зориудын бус үйлдвэрлэлээс гарах хаягдлыг бууруулах буюу устгах арга хэмжээ Тал бүр Хавсралт В-д дурдсан химийн бодис бүрийн хүний үйл ажиллагаатай холбогдон бий болсон гарц хаягдлыг бууруулах, боломжтой бол бүр мөсөн зогсоох зорилгоор дараах наад захын арга хэмжээг авна. Үүнд: Эдгээр стратеги болон энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд гарсан ахиц ололтыг 5 жил тутам хянан үзэхэд гарах үр дүн; хяналтын үр дүнг 15 дугаар зүйлийн дагуу гаргах илтгэлд тусгана.<sup>42</sup></p>	<p><b>6.8.</b> Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолтыг төсөл хэрэгжүүлэгч хариуцан, байгаль орчны мэргэжилтэн, судлаачдын оролцоотой боловсруулна.</p> <p><b>6.11.</b> Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг тухайн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хэмжээнд хийлгэх хүсэлтийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн засаг дарга байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болох ба шийдвэрийг энэ хуулийн 6.3-д заасны дагуу гаргана.</p> <p><b>7.3.</b> Төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээ, эсхүл тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээнд мэргэжлийн талуудыг оролцуулах, Үнэлгээнд төсөл хөтөлбөрийн үе шат бүрийн онцлогийг нарийн тооцож, тодорхой хугацааны давтамжтай хийх.</li> <li>- Үнэлгээг тогтмол хийх шаардлагад төсөл, хөтөлбөрийн үе шат, хугацаанаас гадна тухайн орон нутгийн байгаль экологийн нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлт, хууль тогтоомж болон техник, технологийн шинэчлэл зэрэг хүчин зүйлс багтана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийг тодорхойгүй нөхцөлөөр ангилж, зарим төсөлд тодотгол үнэлгээ хийх шаардлагагүй, зарим төсөлд зөвхөн талуудын хүсэлтээр үнэлгээ хийж байхаар зохицуулсан.</li> <li>- Нөлөөллийн үнэлгээг анх удаа хийхээс бусад тохиолдолд тухайн тайланг төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдэд танилцуулахгүй байхаар заасан.</li> <li>- Нөлөөллийн үнэлгээг тогтмол хугацаанд хийх болон зайлшгүй нөхцөл, шаардлагын улмаас хийх, түүний үр дүнг танилцуулах зэрэг БОНБУ хийхэд харгалзах нөхцөлүүдийг оновчтой тодорхойлоогүй.</li> <li>- Нөлөөлөлд өртөж болзошгүй талуудыг урьдчилан шууд зааж, хэт явцуу буюу зөвхөн төсөл хэрэгжих “баг, хорооны иргэд” байна гэж тодорхойлсон.</li> </ul>
<p><b>Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц</b></p> <p>Энэхүү конвенцод оролцогч Талууд: Бохирдсон газраас үүсэж болох аливаа эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг явуулахдаа байгаль орчинд аюулгүй аргыг ашиглан явуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд бохирдсон газрын мөнгөн ус эсхүл түүний нэгдлээс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн үнэлгээг хийнэ.<sup>43</sup></p> <p>Талууд өөрсдийн нөхцөл байдал, чадавхыг харгалзан дараах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, сайжруулах талаар хамтран ажиллана: Үүнд: (в) Мөнгөн ус, түүний нэгдлийн хүн амд, нэн ялангуяа эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх нийгэм, эдийн засгийн болон амьдралын хэв маягт үзүүлэх нөлөөллийн үнэлгээнээс гадна хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ.<sup>44</sup></p>			

<sup>42</sup> Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцын 5 дугаар зүйл. Зориудын бус үйлдвэрлэлээс гарах хаягдлыг бууруулах буюу устгах арга хэмжээ, 5.(v) дэх хэсэг;

<sup>43</sup> Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын 12 дугаар зүйл. Бохирдсон газар, 12.2. дахь хэсэг;

<sup>44</sup> Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын 19 дүгээр зүйл. Судалгаа шинжилгээ, мониторинг, 19.1 дэх хэсэг;



Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
<p><b>Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай Боннын конвенц</b></p> <p>Нэгдүгээр хавсралтад орсон нүүдлийн зүйлүүдийн тархац нутгийн бүсийн улс болох Тал дараах зүйлд хүчин чармайлт тавина: зүйлүүдийн нүүдэлд ноцтой саад тогтор болохуйц үйл ажиллагааны сөрөг нөлөө, саад бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг зайлуулах, хохирлыг багасгах буюу арилгах.<sup>45</sup></p>	<p><b>7.6.</b> Улсын хэмжээнд үнэлгээний шинжээч болон тэдгээрийн үйл ажиллагааг удирдан зохицуулах ерөнхий шинжээчээр байгаль орчны чиглэлээр 8-аас дээш жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно.</p> <p><b>7.11.</b> Тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хамрах цар хүрээ нь өндөр байх боломжтой төслийн үйл ажиллагааг “их”, хязгаарлагдмал байх боломжтой төслийн үйл ажиллагааг “дунд”, доогуур байх боломжтой төслийн үйл ажиллагааг “бага” гэж тус тус ангилна.</p> <p><b>7.12.</b> Их ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд 5 жил, дунд ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд 10 жил тутамд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд бага ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд энэ хуулийн 7.12-д заасан нөхцөл үүсээгүй тохиолдолд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй.</p>	<p>Конвенцод тухайн төслийн том, жижиг эсэх нь үнэлгээний шалгуур болохгүй гээд, харин тухайн газар, нутаг түүний биологийн олон янз байдал, онцлогийг харгалзах нь чухал болохыг анхааруулж, аливаа төсөл бүрийн экологийн үр дагаврыг заавал тооцсон байхыг шаарджээ.</p> <p>Тэрчлэн үнэлгээ хийхэд дараах зүйлсийг анхаарахыг тодруулжээ.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээ хийх ажилтанд тавигдах шаардлага;</li> <li>- Үнэлгээ хийх хугацаа, давтамж;</li> </ul>	<p>- Байгаль орчны нөхцөл байдал, төслийн нөлөөгөөр үүсэж болох эрсдэл зэргийг мэргэшсэн шинжээч, мэргэжилтнээр хийлгүүлэх талаар шаардлага тусгаагүй.</p>
<p><b>Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч Талууд ус, намгархаг газарт судалгаа, шинжилгээ, менежмент, харуул хамгаалалтын ажил эрхлэх хүмүүсийг сургалтад хамруулах ажлыг гүйцэтгэнэ.<sup>46</sup></p> <p><b>Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенц</b></p> <p>Хэлэлцэн тохирогч талууд: Талууд уур амьсгалын өөрчлөлтийг урьдаас үнэлэх, өөрчлөлтийн шалтгааныг арилгах, түүнийг хамгийн бага болгох, түүний сөрөг үр дагаврыг нь бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна...<sup>47</sup> Нийгэм, эдийн засаг, экологийн бодлого явуулах арга хэмжээг хэрэгжүүлэх мөн байгаль орчны чанар, хүн амын эрүүл мэнд, эдийн засагт үзүүлэх сөрөг үр дагаврыг хамгийн бага болгох зорилгоор үндэсний хэмжээнд тодорхойлогдсон үр дагаврыг үнэлэх гэх мэт арга зүй боловсруулж хэрэглэх, уур амьсгалын өөрчлөлтийн үйлчлэлийг зөөлрүүлэх, түүнд дасан зохицох зорилготой, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үнэлэлт дүгнэлтийг аль болох тооцох.<sup>48</sup></p>			

<sup>45</sup> Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай Бонны конвенцын 3 дугаар зүйл. Устгах аюулд орсон нүүдлийн зүйлүүд: 1 дүгээр хавсралт;

<sup>46</sup> Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенцын 4 дүгээр зүйл, 4.5 дахь хэсэг;

<sup>47</sup> Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенцын 3 дугаар зүйл. Зарчмууд, 3.3 дахь хэсэг;

<sup>48</sup> Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенцын 4 дүгээр зүйл. Үүрэг, амлалт, 4.е дэх хэсэг;

Олон улсын гэрээний холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Анхаарах асуудал
	<p><b>7.14.</b> Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.12-т заасан хугацааг харгалзахгүй нэмэлт тодотгол хийх хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагад гаргана.</p> <p><b>7.15.</b> Энэ хуулийн 7.12-т үүссэн нөхцөлийн дагуу хийж байгаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад мөн энэ хуулийн 7.3.1, 8.4.8-д заасан санал, хэлэлцүүлгийн тайланг шинээр авч ирүүлэхийг шаардахгүй.</p> <p><b>8.4.8.</b> энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хороо иргэдэд хийсэн танилцуулгын тайлан;</p> <p><b>10.5.</b> Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулна.</p> <p><b>14.1.3.</b> Энэ хуулийн 8.4.6-д заасан төсөл уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг төсөл эхлэхээс өмнө суурь түвшинд, төсөл хэрэгжсэнээс хойш 5 жил тутамд, төсөл хаагдахаас 3-аас доошгүй жилийн өмнө хаалтын төлөвлөгөөг тус тус боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх.</p> <p><b>20.3.</b> Энэ хуулийн 7.7-д заасан нөлөөллийн үнэлгээний журам, ангилалд заагаагүй аливаа төсөлд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ шаардахгүй.</p>		

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь зорилгын хувьд байгаль орчны чиглэлээрх Монгол улсын олон улсын гэрээний үзэл баримтлалд нийцэж байна. Гэвч хуулийн төслийн зарим заалт нь гэрээний үзэл санаа, зарчмын шинжтэй зарим үндсэн асуудлаас зөрүүтэй, гэрээний үүргээс ухарсан шинжтэй байгаа нь хуулийн төслийг тавьсан зорилгодоо хүрэх чадамжгүй болгож, БОНБУ-ний ач холбогдол, үр нөлөөг бууруулахаар байна.

Иймд хуулийн төслийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авах нь зүйтэй. Үүнд:

1. Монгол Улс эдийн засгийн өсөлт, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр хүчин чармайлт гаргаж байгаа энэ үед олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн гэрээний үүргээ биелүүлэх нь чухал юм. Ийнхүү олон улсын гэрээний үүргээ биелүүлэхэд гаргаж буй хүчин чармайлт, ахиц дэвшлийг хууль тогтоомжийн өөрчлөлтөөр нотлон харуулах;
2. Одоогийн хуулийн төслийг сайжруулахад 2022 онд УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас гаргасан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээний дүгнэлтийг анхаарах нь зүй. Ялангуяа БОНБУ-нд иргэдийн оролцоог хангах асуудлыг анхааралтай авч үзэх;
3. Хууль тогтоомжийн төслийг олон улсын гэрээнд бүрэн нийцүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;
4. Уурхайн үйл ажиллагааны үе шат бүрд харилцан адилгүй техник, технологи ашигладаг тул байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь харилцан адилгүй байдгийг харгалзан төслийг зөвхөн цар хүрээгээр нь жижиг, том хэмээн ангилан ялгахгүйгээр заавал үнэлгээ хийх, нэмэлт тодотгол хийх нөхцөл, хугацааг тодорхой болгох;
5. БОНБУ нь тухайн төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тооцож, түүнийг бууруулах арга хэмжээг цогцоор нь төлөвлөгөөрөө төсөл хэрэгжүүлэгчдэд аргагүйн зөвлөмж болох чухал баримт бичиг юм. Тухайлбал, ус болон эрчим хүчний хэрэглээг бууруулах, газрын эвдрэл, хог хаягдлын ялгаруулалтыг бууруулах, бохирдлоос сэргийлэх, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийг амжилттай хэрэгжүүлэхэд авах иж бүрэн арга хэмжээг БОНБУ-ээр тодорхойлдог. Иймд үнэлгээний мэргэжилтэн, судлаачдад тавих шалгуурыг сайжруулж, жил бүр багц цагийн сургалтад хамруулдаг болох, сургалтын хөтөлбөрийг олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсруулж мөрдөх нь зүйтэй;
6. Олон нийтийн хяналт, оролцоог хангах талаарх 4 дүгээр бүлгийн зохицуулалтыг эргэн харж, төрийн холбогдох байгууллага, төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний мэргэжлийн байгууллагууд нөлөөллийн үнэлгээний явцад болон хэрэгжилтийн шатад иргэдийн оролцоог хангах, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх нөхцөлийг хангах үүргийг хуульчлах.

### Хуулийн төсөлд өгөх санал

№	Хуулийн төслийн холбогдох заалт	Өөрчлөх саналын томъёолол
1.	6.10.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны газар хариуцна.	6.10. “...төлөвлөгөөнд тусгуулж...” гэсний дараах хэсгийг “...хэрэгжилтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны газар орон нутгийн иргэдтэй хамтран хяналт тавина” гэж өөрчлөх.

№	Хуулийн төслийн холбогдох заалт	Өөрчлөх саналын томъёолол
2.	7.7. Нөлөөллийн үнэлгээний журам, ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, ангилалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадалгаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, дүйцүүлэн хамгаалал, нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана.	7.7. “Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадалгаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, дүйцүүлэн хамгаалал, нэмэлт тодотгол, нийгмийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана” гэж өөрчлөх.
3.	6.8. Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолтыг төсөл хэрэгжүүлэгч хариуцан, байгаль орчны мэргэжилтэн, судлаачдын оролцоотой боловсруулна. 7.6. Улсын хэмжээнд үнэлгээний шинжээч болон тэдгээрийн үйл ажиллагааг удирдан зохицуулах ерөнхий шинжээчээр байгаль орчны чиглэлээр 8-аас дээш жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно. 7.10. Холбогдох хууль тогтоомжоор тухайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг баталгаажуулах эрх бүхий байгууллага тодорхойгүй бол төсөл хэрэгжүүлэгч байгууллага өөрөө баталгаажуулж ирүүлнэ.	6.8. “...судлаачдын оролцоотой боловсруулна” гэснийг “...холбогдох чиглэлээр нарийн мэргэшсэн судлаачдын оролцоотой боловсруулна” гэж өөрчлөх. 7.6. “...8-аас дээш жил ажилласан...”, гэснийг дараах хэсгийг “...уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, цөлжилт, хог хаягдал зэрэг асуудлаар зайлшгүй шаардлагатай сургалтын хөтөлбөрт хамрагдсан байгаль орчинд нөлөөлөх байдал үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно” гэж өөрчлөх. 7.10. “Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар заавал баталгаажуулна” гэж өөрчлөх
4.	7.11. Тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хамрах цар хүрээ нь өндөр байх боломжтой төслийн үйл ажиллагааг “их”, хязгаарлагдмал байх боломжтой төслийн үйл ажиллагааг “дунд”, доогуур байх боломжтой төслийн үйл ажиллагааг “бага” гэж тус тус ангилна. 7.12. Их ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд 5 жил, дунд ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд 10 жил тутамд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд бага ангилалд хамаарах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд энэ хуулийн 7.12-д заасан нөхцөл үүсээгүй тохиолдолд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй.	7.11. “Тухайн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хамрах цар хүрээ нь өндөр байх боломжтой төслийн үйл ажиллагааг, төслийн үргэлжлэх хугацаатай харьцуулан “их”, “дунд”, “бага” гэж тус тус ангилна” гэж өөрчлөх. 7.12. “Дээрх ангиллаас хамааран нөлөөллийн үнэлгээнд 2-5 жил тутамд нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэнэ. Нэмэлт тодотгол хийх хугацааг тогтоохдоо дараах хүчин зүйлсийг харгалзана. 7.12.1. Төсөл хэрэгжүүлэх газар нутгийн онцлог, 7.12.2. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр бий болсон нөхцөл байдал, 7.12.3. Газрын доройтол, цөлжилтийн нөхцөл байдал, 7.12.4. Төслийн үргэлжлэх хугацаа, үе шат, 7.12.5. Төслийн хүрээнд ашиглах тоног төхөөрөмж, технологи, түүний өөрчлөлт” гэж өөрчлөх.
5.	7.14. Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.12-т заасан хугацааг харгалзахгүй нэмэлт тодотгол хийх хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагад гаргана.	7.1.4. “...нэмэлт тодотгол хийх хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагад гаргана” гэснийг “...хугацааг харгалзахгүй нэмэлт тодотгол хийнэ” гэж өөрчлөх.

№	Хуулийн төслийн холбогдох заалт	Өөрчлөх саналын томъёолол
6.	<p>7.15. Энэ хуулийн 7.12-т үүссэн нөхцөлийн дагуу хийж байгаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад мөн энэ хуулийн 7.3.1, 8.4.8-д заасан санал, хэлэлцүүлгийн тайланг шинээр авч ирүүлэхийг шаардахгүй.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 7.3<sup>1</sup>.1. Сум, дүүргийн засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээтэй холбоотой хүсэлтийг 14 хоногт судлан, энэ хуулийн 7.7-д заасан журмын дагуу хариу хүргүүлнэ.</li> <li>- 8.4.8. энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хороо иргэдэд хийсэн танилцуулгын тайлан;</li> </ul>	<p>7.15. <i>"Төлөвлөгөөт нэмэлт тодотгол болон энэ хуулийн 7.12-т заасан нөхцөлийн дагуу хийж байгаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад иргэдийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, иргэдээс гарсан саналыг тайланд тусгасан байна"</i> гэж өөрчлөх.</p>
7.	<p>8.4.8. энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хороо иргэдэд хийсэн танилцуулгын тайлан;</p>	<p>8.4.8. <i>"энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэл, санал"</i> гэж өөрчлөх.</p>
8.	<p>8.7. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална.</p>	<p>8.7. <i>"Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь хээрийн судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг дөрвөн хувь бэлтгэж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсөл хэрэгжүүлэгч болон төсөл хэрэгжих сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт тус бүр нэг хувийг өгч, нэг хувийг өөртөө үлдээх бөгөөд тэдгээр нь адил хүчинтэй байна. Байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална"</i> гэж өөрчлөх.</p>
9.	<p>10.5. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>10.5. <i>"...мэргэжлийн байгууллага хамтран" гэсний дараах хэсгийг "...төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулж, аливаа сонирхсон этгээдийг танилцах боломжоор хангана"</i> гэж өөрчлөх.</p>
10.	<p>14.1.5. иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.</p>	<p>14.1.5. <i>"төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн төсөл, үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялаг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэлтэй нээлттэй танилцах боломжоор иргэдийг хангана"</i> гэж өөрчлөх.</p>
11.	<p>18.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээ хийгдэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.</p>	<p>18.1. <i>"...хөтөлбөр төлөвлөгөө болон" гэсний дараах хэсгийг "...бүх төслийн мэдээлэл, түүнд хийсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ"</i> гэж өөрчлөх.</p>
12.	<p>18.3. Стратегийн үнэлгээнд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон эсхүл бичгээр санал авна.</p>	<p>18.3. <i>"...бичгээр..." гэсний дараа "...эсхүл цахим хэлбэрээр санал авна"</i> гэж нэмэх.</p>



№	Хуулийн төслийн холбогдох заалт	Өөрчлөх саналын томъёолол
13.	18.4. Тухайн төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдэд танилцуулах шаардлагатай байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийн ангиллыг энэ хуулийн 7.7-д заасан журмаар батална.	18.4. “Тухайн төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэд болон тухайн орон нутгийн сонирхсон иргэдээр байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг заавал хэлэлцүүлж, санал авах ба хэлэлцүүлэг зохион байгуулах үйл явцыг 7.7-д заасан журмаар зохицуулна” гэж өөрчлөх
14.	18.5. Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.	18.5. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээний мэдээллийг хүртээмжтэй байдлаар нутгийн иргэддээ түгээх ба энэ талаар тухайлан хүсэлт гаргасан этгээдэд боломжтой бүхий л мэдээллийг бичгээр гаргаж өгнө” гэж өөрчлөх.
15.	20.3. Энэ хуулийн 7.7-д заасан нөлөөллийн үнэлгээний журам, ангилалд заагаагүй аливаа төсөлд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ шаардахгүй.	20.3. “Байгалийн баялгийг ашиглах аливаа төсөлд байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг заавал хийнэ” гэж өөрчлөх.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Ном, гарын авлага

- Д.Бямбажав, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: Оролцогч талуудын судалгаа”, 2021 он, УБ;
- Б.Баяржаргал Ж.Чанцалдулам О.Батболд нар, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо” гарын авлага, 2022 он, УБ;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэх механизмын бүтээмжийн үнэлгээ”, 2020 он, УБ;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл /2023 оны I-XII сар/” 2024 он, УБ;
- Н.Баярсайхан, “Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг”, 2024 он, УБ;
- Хүний эрх хөгжил төв ТББ, “Монгол улсад уурхайн үйл ажиллагаа малчин иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлон үнэлэх судалгаа”, 2023 он, УБ;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайлан, 2022 он, УБ;

- Ж.Амарсанаа, Б.Чимэд нар, Олон улсын гэрээний тухай монгол улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2011 он, УБ;

### Хууль тогтоомжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 он;
- Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль, 2016 он;
- Ашигт малтмалын тухай хууль, 2006 он;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он;
- Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он;

### Цахим хуудас

- Монгол Улсын Их Хурал <https://www.parliament.mn/>
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам <https://met.gov.mn/>
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан <https://www.eic.mn/eia/>
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам <https://mmhi.gov.mn/>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn>

ШҮҮМЖ ӨГСӨН:  
Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын  
хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар  
хот-14240, Сүхбаатар дүүрэг,  
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207  
Веб: [www.forum.mn](http://www.forum.mn)  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)